



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г Амарын гуламж, Солёнын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.05.01 № 1343
танай _____-ны № _____-т

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН
НЭР ДЭВШИХ ИРГЭН Б.БАТЦЭЦЭГ
ТАНАА

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Болормаагийн Батцэцэгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Болормаагийн Батцэцэгийн Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр


ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Болормаагийн Батцэцэгийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (3 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Сонгинохайрхан дүүргийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 3 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИНБААТАР



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ
СОНГУУЛИЙН 43 ДУГААР ХОРООНООС
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ

БОЛОРМААГИЙН БАТЦЭЦЭГ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Улаанбаатар хот
2020 он



ЗӨВ ШИЙДЭЛ

ОРШИЛ

Нутгийн өөрөө удирдах байгууллагын хамгийн чухал эрх мэдэл нь оновчтой шийдвэр гаргах эрх юм. Сүүлийн жилүүдэд батлагдаж байгаа хууль тогтоомжоор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ихээхэн эрх, үүрэг нэмэгдэж байгаа бөгөөд Хурлаар батлагдах журам, хөтөлбөр, төлөвлөгөө, хяналт тавин ажиллах ажлын цар хүрээ тэлэгдэж байгаа юм.

Энэ утгаараа шат шатны төрийн байгууллага ИТХ өөрийн эрх хэмжээний хүрээнд батлан гаргасан тогтоол, журам, хөтөлбөр, төлөвлөгөөнд зарим зохицуулалтыг орхигдуулсан, зарим зүйлийг нарийвчлан зохицуулаагүй зэрэг тохиолдлууд гарч байна. Мөн иргэдэд үйлчилэх анхан шатны нэгж болох хорооны үйл ажиллагааны үйлчилгээ нь төдийлөн оновчтой, хүртээжмтэй байж чадахгүй байгаа гэж дүгнэж байна.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа нь өөрөө иргэдийн амьдрах орчин нөхцлийг сайжруулах, холбогдох эрх зүйн зохицуулалтыг оновчтойгоор шийдвэрлэн тогтоол, дүрэм журам гаргах нь өөрийн дүүргийн газар нутгийн онцлог болон иргэдийн амьдрах орчин нөхцөлд уялдуулан аливаа шийдвэр гаргах нь иргэд болоод аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, амьдралыг хөнгөвчлөх боломж бүрдэнэ гэж найдаж байна.

Иймд төрийн албанд анхан шатны нэгжээс авахуулаад шат шатны төрийн байгууллага болон улс төрийн байгууллагад ажиллаж хуримтлуулсан багахан дадлага туршлагадаа тулгуурлан иргэдийн амьдрах орчин нөхцлийг сайжруулах үйл ажиллагаанд гар бие оролцох нь зүйтэй гэж үзлээ.

ЗОРИЛГО: Сонгинохайрхан дүүрэг нь нийслэл хотын баруун талд орших Сонгино хайрхан уулын нэрээр нэрлэгдсэн юм. Сонгинохайрхан дүүрэг нь Монгол улсын хүн амын 10.1 хувь, Улаанбаатар хотын хүн амын 22.3 хувь, газар нутгийн 25.5 хувийг тус тус эзлэн оршиж байна. Сонгинохайрхан дүүрэг нь 1200.6 км² газар нутагтай ба нийслэлийн Баянгол, Хан-уул дүүргүүд, Төв аймгийн Алтанбулаг, Баянчандмань, Батсүмбэр, Борнуур, Баянцогт сумдуудтай хиллэн оршдог. Дүүргийн газар нутгийн 22.0 хувь нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 19.4 хувь нь ойн сав газар, 3.6 хувь нь зам шугам байна. 322458 хүн амтай 43 хороотой гэр хороолол, байран хороолол хосолсон дүүрэг юм.

Нийслэлийн есөн дүүргээс Сонгинохайрхан, Баянзүрх хамгийн ачаалал ихтэй. Хүн амын тоо 300 мянга хол давжээ. Тиймээс хүн амын тоо, нягтаршлыг үндэслэн уг хоёр дүүргийг хуваах санал НИТХ гаргаад буй. Энэ хүрээнд 15 мянгаас дээш хүн амтай дүүргийг хуваахаар болсон байна. Ингэснээр Сонгинохайрхан дүүрэгт шинээр 11 хороо нэмж, одоо 43 хороотой болжээ.

Сонгинохайрхан дүүргийн 43 дугаар хороо нь 4000 гаруй хүн амтай дан гэр хорооллоос бүрдсэн хороо юм.

Иймд тус хорооны хүн амын амьдралыг зохицуулсан, иргэд оршин суугчиддаа чиглэсэн, нийтийн эрх ашигт нийцсэн, иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх дүүрэг хорооны дүрэм, стандартыг бий болгож,



1117145633
3XA0612 9077278

тулгамдсан асуудлаа оорийн онцлогт тохируулан шийдвэрлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

ЗОРИЛТ:

- ❖ Хороог нэгдсэн стандарттай болгож, иргэдийн сурч хөдөлмөрлөх, аюулгүй орчинд амьдрах, зорчих аятай таатай нөхцөлийг бий болгох хөтөлбөр төлөвлөгөөг дэмжиж ажиллана.
- ❖ Иргэдийн оролцоотой, иргэн төвтэй хороо, дүүрэг болох нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө хичээж ажиллана.
- ❖ Жижиг дунд бизнес эрхлэгчидэд бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох мэдлэг олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- ❖ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, ижил түвшинд хүргэхийг зорьж ажиллана
- ❖ Гэр бүлийн гишүүн бүрт хүрэх нийгмийн бодлого, зорилтот бүлэгт үзүүлэх халамж, дэмжлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.
- ❖ Ногоон эко хороо болгох зорилтыг дэвшүүлж ажиллана. Хашаа хороо болон аж ахуйн нэгж эргэн тойрондоо ногоон байгууламжаар тохижуулсан иргэн аж ахуйн нэгжийг урамшуулах дэмжих ажлыг дэмжинэ.
- ❖ Хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин боловсруулах, ашиглах, төслүүдийг нэгж хог хаягдлыг нэгдсэн стандарттай болгох ажлын төсөл боловсруулан дэмжиж ажиллана.
- ❖ Иргэд хүүхэд залуучуудын амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог орчныг бүрдүүлэх стандарт хэрэгжүүлж мөрдүүлнэ.
- ❖ Цэцэрлэг сургуулийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн хөтөлбөр төлөвлөгөө аливаа үйл ажиллагаа нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх зохион байгуулахыг дэмжинэ.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН МОНГОЛ УЛСЫН ИРГЭН

 /Гарын үсэг/ **БОЛОРМААГИЙН БАТЦЭЦЭГ**

Упаанбаатар хот

2020 он

